



АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 1/19

Эрдэнэбүлган сум

Г Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.2 дахь заалт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн A/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийн саналыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Булганчимэг (Санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Д.Шүрэнчимэг(Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд : Д.Түвшинбат(Тэтгэвэр ,тэтгэмжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Бүжинлхам (Үйл ажиллагааны нягтлан бодогч)

Б.Жамъянлхундэв (Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч)

Г.Бадамгарва (Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч)

Б.Бямбажав (Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч)

Б.Гэрэлт-Од (Сайн дурын даатгалын байцаагч)

2. Ажлын хэсэг нь 2026 оны Төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийн саналыг холбогдох хууль, дүрэм журам зааврын дагуу үнэн зөв, чанартай боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Булганчимэг)-т даалгасугай.

3. Төсвийн төслийг 06 дугаар сарын 25-ны дотор боловсруулан даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ГЭРЭЛЧИМЭГ